



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

106 дугаар байр, Найрамдалын гудамж 1,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442878, 70442891

Цахим шуудан:emg@bayankhongor.moh.gov.mn

2023. 11. 10 № 10-16-02/074/21

Барилгын зурагт эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

ЦЭСДА ХХК-с ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багт баригдах 280 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын загвар зурагт Эрүүл ахуй тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/07 дугаар удирдамж болон холбогдох стандарт, норм дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахаар 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт хийлээ. Уг барилга нь 2019 онд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт баригдсан нэг маягын зураг холболтоор барихаар болсон байна. 2019 оны 12 сары 18-ны 2019/11/14 тоот магадлалын дүгнэлттэй.

Барилга байгууламжийн зориулалт:

Барилгын зургийг "ЦЭСДА" ХХК гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/38 тоот захирамжтай, 5244 метр квадрат хэмжээтэй, 6409011012 нэгж талбарын дугаартай, боловсролын байгууллага зориулалтаар олгосон байна.

Уг барилга байгууламж нь ногоон байгууламж, авто машины зам талбайтай, налуу зам төлөвлөсөн, 2 давхар 46.8м*25м хэмжээтэй, зоорьгүй.

Нэгдүгээр давхартаа 6 бүлэг (хүлээн авах, хувцас солих өрөө, бүлгийн анги, оп хураах өрөө, ариун цэврийн өрөө), эмчийн өрөө нэг урсгалтай (ариун цэврийн өрөө, үзлэгийн өрөө, тусгаарлах өрөө, ариун цэврийн өрөө), узелийн өрөө, гал тогоо (хоол үйлдвэрлэл, бэлтгэл, 3 агуулах, угаалга, ажилчдын хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө), багш нарын ариун цэврийн өрөө, харуул хамгаалалтын өрөө.

Хоёрдугаар давхарт 5 бүлэг (хүлээн авах, хувцас солих өрөө, бүлгийн анги, оп хураах өрөө, ариун цэврийн өрөө), урлагын танхим, дуу хөгжмийн танхим (Багшийн өрөө), чийрэгжүүлэлтийн танхим, санхүү нягтлангийн өрөө, багш нарын өрөө, эрхлэгчийн өрөө, багш ажилчдын ариун цэврийн өрөө төлөвлөсөн байна.

Ус хангамж, бохир ус зайлуулалтын байдал: Ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдох "Чандмань-Баянхонгор" ХК-ний 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 26/2023 дугаартай техникийн нөхцөлтэй. Ус хангамжийн өөрийн эх үүсвэрээр.

Дулаан хангамж, агаар сэлгэлтийн байдал: "Чандмань-Баянхонгор" ХК-ний 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 03/2023 дугаартай дулаанаар хангах техникийн нөхцөлтэй.

Инженер геологийн судалгаа: Инженер геологийн судалгааны ажлыг "Топ гео техник" ХХК гүйцэтгэсэн.

Дээрх байдлыг үндэслэн ДҮГНЭХ нь:

Барилга байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгэхэд эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй.

Цаашид авах арга хэмжээ:

1. Архивын өрөө, бичиг хэргийн өрөө төлөвлөх.

- 2.Үндны усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох (150метр)
- 3.Ариун цэврийн өрөөний шалны төвшин бусад өрөөний шалнаас -2,5-3 см доошоо сууж, хаягдал усны трамп хийхээр төлөвлөн, гүйцэтгэх.
- 4.Хоол үйлдвэрлэлийн хэсэгт агуулахыг нэмэх.
- 5.ХБИ-н ариун цэврийн өрөө төлөвлөх.

Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гардлын эрхийн хүрээнд:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх /Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана./, 14.2 дахь /Улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг дээд шатны улсын байцаагч хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ. Хэрэв гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвэл гомдлоо шүүхэд гаргаж болно./

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



ХҮЛЭЭН АВСАН:
БИЧИГ ХЭРЭГ *Б.Даваасүрэн* Б.ДАВААСҮРЭН